

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ХАЛДВАРЫН БҮС ӨВЧНИЙ АСУУДАГ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН О.ОДМААГИЙН 2025 ОНЫ II
УЛИРАЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшит	Хүрэх түвшин /эхний хагас жил/	Хүрсэн түвшин\биелэлт			
	1	2	3	4	5	6	7	
Зорилт 1. Хүн амын дунд зонхилон тохиолдож буй өвчлөл тухайлбал элэг, хөх, умайн хүзүүний хорт хавдар, чихрийн шижин, цусны даралт ихсэлт өвчний эрт илрүүлэх үзэлт хамралтыг нэмэгдүүлэх								
1.	Арга хэмжээ №1.1 Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгийг эрүүл мэндийн байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд эрчимжүүлнэ.	ХБӨ-ний эрт илрүүлэг үзэлт хамрагдалтын дундаж хувь	52%	30%	Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийн артерийн даралт ихсэх өвчин илрүүлэх үзэлт 5911 (21,6%) иргэн, чихрийн шижин илрүүлэх үзэлт 6076 (30,6%) иргэн, умайн хүзүүний эсийн шинжилгээнд 669 (13,1%) иргэн, хөхний хавдар илрүүлэх үзэлт 2992 (24,6%) иргэн, элэгний хавдарын эрт илрүүлэгт 8224 (24,4%) иргэн хамрагдаж хамрагдавал зохих иргэдийн 22,8% нь халдварын бус үзэлт, үлдэх хувь нь бусад урьдчилан сэргийлэх үзэлт хамрагдсан байна. Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд 150,250 иргэнд үзлэг шинжилгээ хийсний 36,7 %-д нь урьдчилан сэргийлэх болон идэвхтэй хяналт тандалтын үзлэг хийгдсэн ба өмнөх оноос 4,6% өссөн үзүүлэлттэй байна.	2025	78%	
		Чихрийн шижин, цусны даралт ихсэлт өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгийн хувь	64%	30%				
		Элэг, хөх, умайн хүзүүний хорт хавдраас урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгийн хувь	43,9%	30%				

2. Арга хэмжээ №1.2. Иргэн бүр 2 жилд 1 удаа эрүүл мэндийн даатгалаар тухайн насны бүлэгт тохирох үзлэг, оношилгоо, шинжилгээнд үнэ төлбөргүй үзлэгт хамрагдах боломжтой иргэдэд сурталчилгах, үзлэг арга хэмжээг идэвхжүүлэх	Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт /бүх нас/	37%	40%	Эрүүл мэндийн сайдын 379 дүгээр тушаалын хүрээнд зохион байгуулагдаж буй эрт илрүүлэг үзлэгийн хамралт хагас жилийн байдлаар 30382 /40.5%, 0-17 насанд 18977 /67.8%, 18-дээш 11405 /24.2%/ хамрагдалттай байна. Насан хүрэгчдийн хамрагдалт муу байхатай холбоотой 1-4 дүгээр саруудад Жасминдратай гэрээлэн хамтран ажиллаж 1200 иргэнийг хамруулсан. Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн 100.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эрт илрүүлгийн дэмжих төвийн хүчин чадал, багаж тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлсэн. БОЭТ-ийн дэмжих төвийг бүрэн тохижуулж өдөрт 50-60 иргэнд түргэн шуурхай, тав тухтай үйлчилгээ авах боломж нөхцөлийг бүрдүүлсэн. Мөн эрт илрүүлэг хийх эмч мэргэжилтний нөөцийг нэмэгдүүлэн 2 ходоодны дуран, 2 дурангийн эмч, 1 сувилагч ажиллаж байна. Хагас жилийн байдлаар эрт илрүүлгийн төвд 891 хүн хамрагдсан байна.	2025	90%
	Анхэн шатанд үзлэгт хамрагдаж буй 0-17 насны хүүхдийн эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь	67,8%	70%			
	Лавлагаа шатлалын эмнэлэгт үзлэг оношилгоонд хамрагдаж буй 17-оос дээш насны иргэдийн хамрагдалтын хувь	17,8%	20%			

					хүүхдээс 1711/90%/ хүүхдийн зүрхний цахилгаан бичлэг хийгдэж, 453/26.5%/ хүүхдэд өөрчлөлт илэрсэн 2-р шатны үзлэг 06 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулагдаж, хамрагдах ёстой 453 хүүхдээс 262/57.8%/ хүүхэд хамрагдаж, 53/20,2%/ хүүхдэд өөрчлөлт илэрч эмчийн хяналтад орох, зөвлөгөө мэдээлэл өгөх болон лавлагаа шатлалд шилжүүлсэн байна. Шүдний үзлэгт 1594/82,6%/, нүдний үзлэг хэрэглэгдэхүүний хүрэлцээгүй байдлаас болоод 413 /21,4%/ -тай тус тус хамрагдаж байна.		
3.	Арга хэмжээ №1.3. Эрүүл мэндийг дэмжих төвийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах, 18-30 насны хүн амын дундах эрт илрүүлэг зохион байгуулах эрүүл мэндийн байгууллагын хүртээмжийг нэмэгдүүлэх	Эрт илрүүлэгт 18-30 насны хүн амын хамрагдахтын хувь	17,8%	20%	Өмнөговь аймгийн хэмжээнд насанд хүрэгчдийн эрт илрүүлэгт 11,030 иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоо шинжилгээнд хамруулан хамрагдахтын хувь 23,4%-тай хамрагдаж байна. 18-30 насны залуудын дийлэнх нь ажиллаж буй уул уурхайн сэдлбэртэй ажилдын эрт илрүүлэгт гэрээлэн ажиллахаар төлөвлөж байна.	2025	80%
4.	Арга хэмжээ №1.4. ХБӨ-өөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд "Явуулын урьдчилан сэргийлэх үзлэг"-ийг сүм өрхийн эрүүл мэндийн төв болон бусад эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран үе шаттай зохион байгуулна.	Үзлэгийн хамрагдсан иргэдийн тоо	4500	5000	"Өнөөдрийн хяналт- Ирээдүйн хамгаалалт" уриан дор явуулын үзлэг арга хэмжээг 6 суманд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаа. Эхний хагас жилийн байдлаар Ноён, Гурвантэс суманд үзлэг арга хэмжээг зохион байгууллаа. Эрүүл мэндийн газар, бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хамтарсан баг эмэгтэйчүүд, гэмтэл, нүд, чих хамар хоолой, арьс харшил, халдварт өвчин, дотор, эхо гэсэн 8 чиглэлийн дагуу 1106 иргэнд үзлэг, оношилгоо зохион байгуулсан. Нийт хамрагдсан иргэдийн 26.1% малчин иргэн байсан. Үзлэг арга хэмжээний үр дүнд үзлэгээр илэрсэн өвчлөлийн 10,3% -ийг лавлагаа шатлалд шилжүүлсэн. Мөн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр Сургууль цэцэрлэгийн хүүхдүүд, багш	2025	80%

		Нарийн мэргэжлийн үзлэг оношлогоонд хамрагдсан иргэдийн тоо	7%	10%	ажилчид, 11 настай хүүхдүүдийн асран хамгаалалтад эрүүл мэндийн боловсрол олгох сургалт мэдээллийн арга хэмжээг зохион байгуулж нийт 748 иргэнийг хамруулсан байна. Явуулын үзлэг арга хэмжээнд шаардлагатай эм, урвалж оношлуур худалдан авах тендерийн үйл ажиллагаа удаа дараа зарлан, амжилтгүй болсонтой холбоотойгоор дараагийн сумдад ажиллахад эм, урвалжийн нөөц хүрэлцээ болсон. Энэ оны 3.4 дүгээр улиралд Цогтцэгий, Хүрмэн, Мандал-Овоо, Ханхонгор сумдад зохион байгуулахаар төлөвлөж байна.		
	Арга хэмжээ №1.5 ХБӨ- өөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд "Цагаан хад, Шивээ хүрэн хилийн боомтын ажилчид, албан хаагчдад" нарийн мэргэжлийн эмчийн үзлэг арга хэмжээг зохион байгуулах	Үзлэгийн хамрагдсан иргэдийн тоо	-	500	2 боомтод 8-р сараас ажиллахаар төлөвлөөд, худалдан авах ажиллагааг үргэлжлүүлэн хийж бэлтгэл ажил ханган ажиглаж байна.	2025	80%
5		Анхэн шатны эрүүл мэндийн төвд хяналтад авсан өвчлөлийн хувь /илэрсэн өвчлөлөөс/	-	20%			
		Нарийн мэргэжлийн үзлэг оношлогоонд хамрагдсан иргэдийн тоо	-	10%			
	Арга хэмжээ №1.6. Нийтийн эрүүл мэндийг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх эрүүл зөв амьдралын хэв магийг сурталчилан иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлнэ.	Арга хэмжээг хамтран зохион байгуулсан албан байгууллагын тоо	4	2	Иргэдэд эрүүл мэндийн мэдлэг олгох, хандлагыг өөрчлөх, мэдээлэл сургалтыг 11 удаагаар 21 байгууллагын 1438 иргэнийг хамруулан зохион байгуулсан байна.	2025	100%
6.		Сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо	2500	1000			
7.	Арга хэмжээ №1.7. "Эрүүл шүд" орон нутгийн хөтөлбөрийн хүрээнд эрүүл мэндийн	Хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээний тоо	2	1	"Эрүүл шүд" хөтөлбөрийн төслийг боловсруулан АИТХ-н хурлаар батлуулсан. Хөтөлбөрийн үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөнд нийт 10 үйл ажиллагааг төлөвлөн	2025	80%

байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулан амны хөндий, шүдний өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хамтран зохион байгуулж шүд цоорлын тархалтыг бууруулна.	Зохион байгуулсан арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо	12560	4000	хэрэгжүүлж байна. Аймгийн хэмжээнд 8 суманд /ГТ, МН, НН, НО, ХБ, ЦЦ, СЭ, БО/ шүдний тусламж үйлчилгээг хүргэж, 2 суманд кабинет байгуулагдаад байна. Нийт хувийн хэвшлийн 8 шүдний эмнэлэг, Говь Дент төв, БОСГТ зэрэг нийт 18 кабинетаар амны хөндий, шүдний тусламж үйлчилгээг нийт 10202 хүнд хүргэсэн байна. Өнгөрсөн онтой харьцуулахад тусламж үйлчилгээ хүргэсэн хүний тоо 4.6 хувиар нэмэгдсэн байна. Говь Дент анхны цахиур шүдний төв байгуулагдсанаасаа хойш 2023-2025 онд шүдний тусламж үйлчилгээг нийт 18725 хүнд үзүүлсэн бөгөөд үүнээс өвчний үнийр 13770, урьдчилан сэргийлэх үзлэг 4955 хүнд хийсэн. Хагас жилийн байдлаар 5078 иргэнд амны хөндийн тусламж үйлчилгээ, 1254 иргэнд урьдчилан сэргийлэх үзлэг үнэ төлбөргүй зохион байгуулж ажиллаа. Мөн сар бүр дэмжих аяныг зохион байгуулж хүүхдэд ээлтэй сар, онцгой сар, эмч нарын сар, сургалтын сар, сувилалч нарын сар, тусгай хэрэгцээт хүүхдийн сар болон зорилтот бүлгийн иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг хүргэсэн. Орон нутгийн хэмжээнд 24/3 шүдээ угаа аяныг сум, өрх бүр зохион байгуулж, нийт 6005 хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэг, фтор түрхлэг хийсэн ба үзлэгээр цоорлын тархалт 82%, цоорлын эрчим 4.5% байна. Эрүүл мэндийн боловсрол олгох сургалт нөлөөллийн арга хэмжээнд 19849 иргэн, хүүхэд өсвөр үеийнхэн хамрагдсан байна.	
	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	2145	1500		
	Шүд цоорлын тархалтын хувь	72,3%	72%		
	Сумдад үйл ажиллагаа явуулж байгаа кабинетын тоо	6	6		
8. Арга хэмжээ №1.8. Кабинетуудад ажиллах шүдний эмч, сувилалчийн орон тоог нэмэгдүүлэх, эмч мэргэжилтнүүдийг чадавхжуулах арга зүйн сургалтад хамруулна.	Сумдын кабинетад ажиллаж буй мэргэжлийн эмчийн тоо	6	6	Төр, хувийн хэвшилд ажиллаж буй нийт эмч, сувилалч, эрүүл аүйч нарын хамтаарсан "Эрүүл шүд" зөвлөгөөнийг зохион байгуулах удирдамж боловсруулан, 8-р сард хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.	
	Арга зүйн сургалт, зөвлөгөөнд хамрагдсан эмч мэргэжилтний тоо	25	17		
				2025	90%

9.	Арга хэмжээ №1.9. Зорилгот хүүхдийг урьдчилан төлөвлөгөөт хамруулж, эрүүлжүүлэх арга хэмжээг зохион байгуулах.	Сургалтад хамрагдсан хүүхдүүдийн тоо	300	150	Орон нутгийн хэмжээнд 24/3 шүдээ угаа аяныг сүм, өрх бүр зохион байгуулж, нийт 6005 хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэг, фтор түрхлэг хийсэн ба үзлэгээр цоорлын тархалт 82%, цсорлын эрчим 4.5% байна. Эрүүл мэндийн боловсрол олгох сургалт нөлөөллийн арга хэмжээнд 19849 иргэн, хүүхэд өсвөр үеийнхэн хамрагдсан байна. Даланзадгад сумын хэмжээнд 6 настнуудын шүдний үзлэгт нийт 899 хүүхэд хамрагдсан бөгөөд ДАЛАНЗАДГАД сумын ерөнхий боловсролын сургуулиудын хүүхдүүдийн хамрагдалт 93% байна.Өвчлөлийн байдлыг авч үзэхэд Даланзадгад сумын нийт 6 настай хүүхдүүдийн шүд цоорлын тархалт 90,1%-тай, шүд цоорлын эрчим 6,6-тай, нүүр амны гажиг заслын өөрчлөлт 36,6%-тай байна.	2025	80%
		Шүд цоорлын тархалтын хувь	84,5	85%			
		Шүд цоорлын эрчим	5,3	5,2			
		Шүдээ эрдэсжүүлсэн хүүхдийн тоо	350	200			
10.	Арга хэмжээ №1.10. Төр хувийн хэвшлийн түншлэл сайжруулах, хамтын ажиллагааг өргөжүүлэх	Хамтран ажилласан хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын тоо	-	-	Төр, хувийн хэвшилд ажиллаж буй нийт эмч, сувилагч, эрүүл ауйч нарын хамтарсан "Эрүүл шүд" зөвлөгөөнийг зохион байгуулах удирдамж боловсруулан, 8-р сард хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Мөн 6 настны үзлэгтэй холбоотой 11 анхан шатны эрүүл мэндийн байгууллага Говь дөнт анхны цахиур шүдний төв, хэрмэн цахиур шүдний эмнэлэг, Бүтэн жаргал шүдний эмнэлэг, Хатанзаяат шүдний эмнэлгүүд гэрээ байгуулан 1043 хүүхдийг шүдний үзлэгт хамруулаад байна.	2025	95%
11.	Арга хэмжээ №1.11 Алслагдсан суманд амны хөндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх,	Шүдний төвөөр үйлчлүүлж тусламж авсан нийт үйлчлүүлэгчийн тоо	5003	10000	Аймгийн хэмжээнд шүдний эмч, шүдний кабинетгүй 8 сумын эрүүл мэндийн төвд 4 хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах гурвалсан гэрээг байгуулсан. Гэрээ байгуулсан хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд сумдад амны хөндийн тусламж үйлчилгээг хүргэн, тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн ажилласан. Арга хэмжээний хүрээнд аймгийн хэмжээнд 1928 хүүхдээс 1594	2025	90%

					хүүхэд хамруулж 82,6% тай байна. Говь Дөнт анхны цөхиур шүдний төв 3 өрхийн 6 сургуулийн 1-р ангийн 990 хүүхдийн 1-р шатны үзлэгийг амжилттай дуусгасан байна. Цаашид бусад насныханд амны хөндийн тусламж үйлчилгээг үе шаттайгаар хүргэнэ.		
12.	Арга хэмжээ №1.12 Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагыг түшиглэн хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийн талаарх хандлагыг сайжруулж, эрүүл ахуйн дадал хэвшлийг төлөвшүүлэх	Шүд угаах "Бассын арга" заах сургалт хамрагдсан хүүхдүүдийн тоо	-	200	Аймгийн Засаг даргын а/б/з дугаар захирамжийн дагуу шүд угааглын зөв дадал хэвшлийг төлөвшүүлэх, ажлын байрандаа шүдээ тогтмол угаах орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор одоогийн байдлаар 15 байгууллага "шүд угаах хэсэг" байгуулсан. Мөн Сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуульд өдөр бүр "Шүд угаах цаг"-ийг бий болгон хэвшүүлэхээр Даланзадгад сумын ерөнхий боловсролын 3, 4, 5 дүгээр сургууль дээр шүд угаах хэсгийг орон нутгийн 80,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар засварлан тохижуулсан. Мөн Сэврэй, Цогтэций, Хүрмэн сумын ерөнхий боловсролын сургууль дээр шүд угааглын хэсэг байгуулагдан ашиглагдаж байна. Шүд угаах хэсэг бүрт ашиглалт болон эрүүл ахуйн хяналт тавин ажиглаж байна. 2025 оны хичээлийн шинэ жилээс эхлэн шүд угаах дадлыг эрчимжүүлэх сургалт нөлөөллийн аяны арга хэмжээг суралгын дунд зохион байгуулахаар төлөвлөсөн.	2025	90%
13.	Арга хэмжээ №1.13 Говь Дөнт анхны цөхиур шүдний төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх, удирдлагаа арга зүйгээр хангаж ажиллах	Ажиллах бүтэц орон тоо	3 эмч, 4 сувилагч, 1 эрүүл ахуйч	Эмч-4 Сувилагч-4 Эрүүл ахуйч-1	Орон нутгийн хэмжээнд 24/3 шүдээ угаа аяныг нийт 1600 хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэг, фтор түрхлэг хийсэн ба үзлэгээр цоорлын тархалт 82%, цоорлын эрчим 4.5% байна. Дагуу 6 настнуудын эрт илрүүлгийн үзлэг, оношилгоо, эрдэсжүүлэлтийн аян нийт 899 хүүхэд хамрагдсан хамрагдалт хувь 93% байна.	2025	90%
14.	Арга хэмжээ №1.14 Олон нийтийн дунд мэдээллийн	Осол гэмтлийн шалтгаант нийт өвчлөлийн түвшин (10 000 хүн амд)	216,8	150	Аймгийн хэмжээнд нийт осол гэмтлийн өвчлөл 10000 хүнд 71,4 промилль буюу 500 тохиолдол бүртгэгдэж тусламж үйлчилгээ авсан байна.	2025	90%

технологийг ашиглан осол гэмтлийн шалтгаант өвчлөл, нас баралтаас сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулна.	0-5 насны хүүхдийн түлэгдэлтийн түвшин (10 000 хүн амд)	41,1	216	Өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулбал 103 тохиолдлоор буурсан байна. Хүүхдүүдийн дунд 114 осол гэмтлийн тохиолдол бүртгэгдсэн байна. Осол гэмтэлд өртсөн байршлыг авч үзвэл 42,8% гэртээ, 34,2%-гудамж зам, 5,1% сургууль цэцэрлэгийн орчинд тохиолдсон нь өнгөрсөн оноос гэрийн орчин дахь осол гэмтэл буурч, гудамж замын осол нэмэгдсэн байна. Он гарсаар 117 хүн нас барсан ба нийт нас барсан хүний 16,2% нь хорт хавдраар, 9,4% нь зүрхний шигдээс, тархинд цус харвалт зэрэг сэргийлж болох эндэгдлээр, 15,4%/10,000 хүн амд 2,2/ нь осол гэмтлээр, 2,6% нь чихрийн шижин өвчнөөр тус тус нас барсан байна. Осол гэмтлээс сэргийлэх " Алшин бүрд анхаарлаа нэмж - Эрсдэлийг бууруулья" аяны хүрээнд амилуулах суурь тусламжийн сургалтад 68 иргэнийг, ахуйн осол гэмтлээс сэргийлэх сургалтад 380 иргэнийг хамруулсан бөгөөд сургалтыг үргэлжлүүлэн хийж байна. Мөн зуны улиралтай холбоотой зам тээврийн осолд гэмтлийн чиглэлээр ажиллах төлөвлөж байна.	2025	80%
	Амиа хорлох нас барсан тохиолдлын түвшин (10 000 хүн амд)	1,5	41,1			
	Осол гэмтлийн шалтгаант нас баралтын түвшин (10 000 хүн амд)	4,4	1,5			
Арга хэмжээ №1.15. Осол гэмтлээс сэргийлэх ажилд салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах өдөрлөг, аяны арга хэмжээ зохион байгуулна.	Иргэд олон нийтэд чиглэсэн МСС, нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо	4500	2000	Унаж бэртэх, ахуйн осол гэмтлээс сэргийлэх, бага насны хүүхдийн түлэгдэлтээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, зам тээврийн осол гэмтлээс сэргийлэх зөвлөмж постерыг фэйж хуудсаар дамжуулан ойролцоогоор иргэдэд хүргэж байна.Мөн Цагдаагийн газартай хамтран иргэдэд унадаг дугуйгаар замын хөдөлгөөнд оролцох дүрэм, ахуйн осол гэмтлийн талаар зорилтот бүлгийн хүүхдүүдэд мэдээлэл хүргэж байна.	2025	80%
	Цахимд мэдээллийн тоо	-	5			
	Салбар дундыг оролцуулан зохион байгуулсан үйл ажиллагааны тоо /хамтран ажилласан байгууллага/	3	1			
Арга хэмжээ №1.16. Орон нутгийн өвчлөл, нас баралтын болсон зүрх шалтгаант өвчлөлийг	Цусны даралт ихсэлт өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгийн хамрагдахтын хувь	58,6%	58,5%	Халдварт бус өвчний эрт илрүүлэгийн үзлэгийн артерийн даралт ихсэх өвчин илрүүлэх үзлэгт хамрагдавал зохих 27416 иргэнээс 5911 иргэнийг хамруулж, хамрагдалт 21,6%-тай байна. Мөн чихрийн шижин илрүүлэх үзлэгт хамрагдавал зохих 19887 иргэнээс 6067 иргэнийг хамруулж, хамрагдалт 30,6%-тай байна.	2025	90%
	Зүрх судас, цусны эргэлтийн шалтгаант	1,2	1,2			

бууруулах эрт илрүүлгийг нэмэгдүүлэх	өвчлөлийн түвшин (10 000 хүн өмд)			Зүрх судас, цусны эргэлтийн шалтгаант өвчлөл 4160 бүртгэгдсэн ба 10000 хүн өмд 694,2 байна. Оны гарсаар 142 хүн нас барсан ба нийт нас барсан хүний 16,9% нь хорт хавдраар, 32,4% нь зүрхний шигдээс, тархинд цус харвалт зэрэг сэргийлж болох эндэгдлээр, 15,5% нь осол гэмтлээр, 2,8% нь чихрийн шижин өвчнөөр тус тус нас барсан байна. 3-р улиралд "Эрүүл зүрх" аяныг Говийн оюу хөгжлийг дэмжих сантай хамтран зохион байгуулахаар ажиллаж байна.		
	Зүрх судас, цусны эргэлтийн шалтгаант нас баралтын түвшин (10 000 хүн өмд)	15,7	15,7			
Арга хэмжээ №1.17. Орон нутгийн өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болсон зүрх судас, цусны эргэлтийн тогтолцооны өвчлөлийн эрсдлийг үнэлэх судалгааны ажил зохион байгуулах	Судалгааны арга хэмжээнд хамрагдсан сумдын тоо	6	6	3-р улиралд "Эрүүл зүрх" аяныг Говийн оюу хөгжлийг дэмжих сантай хамтран зохион байгуулахаар ажиллаж байна.	2025	90%
	Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо	500	100			
	Үе тэнгийн сургалч багш бэлтгэх	20	-			
	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр иргэдэд хүргэсэн зөвлөгөө мэдээллийн төрөл	10	5			
Арга хэмжээ №1.18. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад халдварт бус өвчин, тэр дундаа зүрх судасны өвчнөөс сэргийлэх, хянах нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багц МонПЭН болон мобайл технологи	МонПЭН технологи нэвтрүүлсэн ЭМБ-ын тоо	-	1	Явуулын үзлэг арга хэмжээнд мобайл технологийн ашиглалтыг сайжруулахад анхаарч ажиллахаар төлөвлөөд байна.	2025	90%

	ашиглан үйлчилгээ үзүүлж байгаа байдалд хяналт тавих, ашиглалтыг нэмэгдүүлэх				
19.	Арга хэмжээ №1.19 Эрэгтэйчүүдэд чиглэсэн нийгмийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх	Кабинетаар үйлчлүүлсэн эрэгтэйчүүдийн тоо	860	600	Өмнөговь аймгийн 18-25 насны эрчүүдийн эрүүл мэндийг хайгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эмчлэн, эрүүлжүүлэх зян, уралдааныг 2025 оны 04 дүгээр сарын 01-нээс 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб, Нийгмийн бодлогын хэлтэс, Эрүүл мэндийн газар хамтран зохион байгуулж байгаа.

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАРЫН БИЕЛЭЛТ

Д/д	Үүрэг даалгавар	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	Үүрэг даалгавар1. Хүний пацилгома вирусийн эсрэг дархлаажуулалтын сургалтад хамрагдсан.	Гүйцэтгэлээр	-	-	Хүний пацилгома вирусийн эсрэг дархлаажуулалтын сургалтыг Ноён, Гуравантэс, Цогтцэций, Ханбогд, Даланзадгад сумдын боловсролын байгууллагын багш нар, 5,6-р ангийн хүүхдүүд, эцэг эх асран хамгаалагчдад "Дархлаажуулалтын 7 хоног" өдөрлөгийг зохион байгуулж зохион байгуулж нийт 1088 иргэдэд мэдээлэл хүргэж ажиллаа.	2025	100%
2	Үүрэг даалгавар2. Улаан буруханы дэгдэлттэй холбоотой ажилласан.	Гүйцэтгэлээр	-	-	Даланзадгад сумын ЕБС-ын 7 сургуулийн нийт 9165 хүүхдүүдийн вакцинжуулалтыг сургууль тус бүрээр шүүж дутуу тунтай хүүхдүүдийг дархлаажуулах, мэдээллийг цахимд оруулах үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан.	1,3-р сард	100%

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хэрэгжүүлэх ажил	Эхлэх, дуусах огноо	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ №1.1. Албан тушаалын онцлогоос хамгаарсан гадаад хэл, мэдээллийн технологийн хэрэглээний болон салбарын хууль тогтоомжид заасан зайлшгүй шаардлагатай ур чадварыг мэргэжлийн сургалтын байгууллагаар дамжуулан, эсхүл бие даан суралцаж эзэмших.	-	Гүйцэтгэлээр	Гүйцэтгэлээр	-	Тухай бүр	100%
2	Арга хэмжээ №1.2. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Эмч, эмнэлгийн мэргэжилтний Мэргэжил Дээшлүүлэх сургалтад	-	Гүйцэтгэлээр	Гүйцэтгэлээр	Суралцаж байна.	2-р сард	100%
3	Арга хэмжээ №1.3. Бичлэг, зураг авах, янзлах төлбөртэй цахим сургалтад хамрагдсан.	-	Гүйцэтгэлээр	Гүйцэтгэлээр	Сургалтад хамрагдсан.	Тухай бүр	100%
	Арга хэмжээ №1.4. Чинсан академийн ярих ур чадвар хөгжүүлэх цахим сургалтад хамрагдсан.	-	Гүйцэтгэлээр	Гүйцэтгэлээр	Цахимгаар суралцаж дууссан.	4-5 сард	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Халдварын бүс өвчний асуудал
хариуцсан мэргэжилтэн

О.Одмаа /  /

2025.06.18